

Батлав. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын дарга

_____/_____
эсхүл (Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газрын дарга)
_____/_____

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

ГЕОАНАЛИТИК ХХК-ийн захирал _____/Э. Мөнхбаатар/

ГЕОАНАЛИТИК ХХК-ИЙН

2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6208916/

Хянасан:

Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын мэргэжилтэн _____

эсхүл (Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газрын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн) _____

Биелэлтийг тайлагнасан:

Геоаналитик ХХК-ийн Захирал _____/Э. Мөнхбаатар/

Геоаналитик ХХК-ийн Лабораторийн менежер _____/Э.Бямбадулам/

Улаанбаатар хот

2024.11.01

АГУУЛГА		Хуудасны дугаар
1	Төлөвлөгөөний гүйцэтгэлийн товч танилцуулга	2-2
2	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	3-7
3	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	8
4	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	8-10
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	11-11
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	12-13
	Дүгнэлт	14
	Тайлангийн хавсралтууд	15
	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах, дүгнэх хуудас	

1. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Геоаналитик” ХХК нь Сүхбаатар дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг, 2017 онд үүсгэн байгуулагдсан эрдсийн түүхий эдийн лаборатори бүхий компани бөгөөд холбогдох хууль тогтоомж, өөрийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг аж ахуйн нэгж юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд Геоаналитик ХХК-ийн эрдсийн түүхий эдийн лабораторийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон БОАЖЯ-ны төслийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэнд (2022.07.06 № 0002227) тусгасан байгаль орчны асуудлуудтай холбогдолтой болзошгүй болон, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус лаборатори нь химийн бодис ашиглах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, Монгол улсын хуулийн дагуу байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг тайлагнахад тус тайлангийн зорилго оршино.

Тус компани нь үйл ажиллагааныхаа хүрээнд байгаль орчны зохистой менежментийг бий болгохын тулд байгаль орчныг хамгаалах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байна.

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төлөвлөгөөний дагуу байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, сэргийлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусган ажиллаж байна.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хийгдсэн ажил
1	Аюултай хог хаягдлыг битүүмжлэл сайтайгаар хадгалах арга хэмжээг авах	Аюултай хатуу болон шингэн хог хаягдлыг битүүмжлэл сайтайгаар хадгалж байна. Улирал бүр аюултай хатуу хог хаягдалыг Түмэн эгшиг ХХК-д гэрээний дагуу шилжүүлсэн. Аюултай шингэн хаягдлыг Элемент ХХК-д шилжүүлсэн.
2	Ажилтан, албан хаагчдад ХАБ-ын хувцас хэрэгслэлийг тогтмол хэрэглүүлж занших	Ажилтан, албан хаагчид ажлын хувцас халадыг тогтмол өмсөж хэвшсэн. Мөн ХАБ-ын бусад хэрэгсэл бээлий, амны хаалт, малгай, нүдний шил, хормогчийг тогтмол өмсөж хэрэглэж байна.
3	Дээж бэлтгэл болон шинжилгээний лабораторид хэрэглэгдэх бүх тоног төхөөрөмжийг үйлдвэрийнх нь стандартын дагуу суурилуулж, бэхлэх, засвар үйлчилгээг тогтмол хийх, дуу чимээ бууруулах арга хэмжээ авах	Дээж бэлтгэлийн өрөөний болон лабораторийн тоног төхөөрөмжийг стандартын дагуу суурилуулж, засвар үйлчилгээг тогтмол хийж байна. Дээж бэлтгэлийн техникч тоног төхөөрөмжийг ажиллуулах үедээ тогтмол чихэвч хэрэглэж хэвшсэн. 2024 оны 9 сард WHA ХХК-аар Хөдөлмөрийн нөхцлийн эрсдлийн үнэлгээ хийлгэсэн. Зөвлөмжүүдийг авч ажиллаж байна.
4	Төсөл хэрэгжих хугацаанд мэргэжлийн байгууллагаар агаарын сорьц авахуулан шинжилгээ хийлгэж, зөвлөгөө авч байх	2024 оны 9 сард WHA ХХК-аар Хөдөлмөрийн нөхцлийн эрсдлийн үнэлгээгээр ажлын байрны агаарт байгаа нарийн ширхэгтэй тоосонцор болон Si шинжилгээ хийлгэж, зөвлөмжүүдийг авч ажиллаж байна.
5	Лабораторийн агааржуулалтын системээс гарч буй хийг бүрэн хоргүйжүүлэх	Лабораторийн агааржуулалтын системийн төгсгөлд том ширхэгтэй тоосонцор болон хүнд металлыг шүүх зориулалттай нүүрсэн филтер суурилуулсан. Филтрийг улирал тутам сольж хэрэглэж байна.



		Зураг1. Агааржуулалтын филтер
6	Лабораторийн агааржуулах хоолойгоор гарч бгаа хийг бүрэн хоргүйжүүлсэнч хийн урсгал хэвийн эсэх	Лабораторийн хийн урсгалынхаа хамгийн эцсийн цэг дээр анемометрээр хэмжилт хийхэд агаарын хийн урсгал хэвийн буюу 9-10м/с хурдыг заасан. Сорох системийг ажиллуулахын өмнө тогтмол анемометрээр хэмжилт хийж шалгадаг.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хийгдсэн ажил
1	Хатуу хог хаягдлыг тусгай цэгт ангилан цуглуулах, гэрээт компани зайлуултал тодорхой хяналт хийх	Аюултай хог хаягдлыг зориулалтын саванд ангилан ялгаж, агааржуулалт сайтай өрөөнд хадгалж гэрээт компанид шилжүүлж байна. Хадгалах хугацаанд 7 хоног бүр хадгалалтын горимыг шалгадаг. Хортой хог хаягдлын бүртгэл мэдээллийг дотооддоо тогтмол бүртгэл хөтөлдөг.

Усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Лабораторийн шинжилгээнээс ихэвчлэн азот, давсны хүчлийн шингэн хаягдал гардаг бөгөөд зориулалтын саванд саармагжуулан хадгалж байна.

Усны төвийн шугам сүлжээнд аль болох ямар нэгэн химийн бодис урвалж алдагдахгүй байх арга хэмжээний хувьд одоогийн байдлаар химийн бодис урвалжийн шингэн хаягдлыг цуглуулан хадгалж байна. Төв шугамд нийлүүлж байгаа хаягдал усанд “SGS IMME Mongolia” ХХК-аар химийн шинжилгээ хийлгэн 18 үзүүлэлтийг MNS 4943:2011 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага стандарттай харьцуулсан. Хүснэгт 1-т шинжилгээний үр дүнг MNS 4943:2011 стандарттай харьцуулсан үр дүнг оруулав.

Хүснэгт 1. Хаягдал усан дах хүнд металлын агуулагыг MNS 4943:2015 стандарттай харьцуулсан үр дүн

Элемент	pH	As	Ca	Cu	Cd	P	Pb	Zn
Нэгж	-	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л
Хаягдал ус 2024.08.17	7.15	0.0035	14.7	<5	<0.01	<0.05	<0.0005	0.013
MNS 4943:2015	6-9	0.01	100	300	0.03	1.5	0.1	3

Элемент	Ni	Mo	Sn	Se	U	Ba	Be	V
Нэгж	мкг/л	мкг/л	мкг/л	мкг/л	мкг/л	мг/л	мг/л	мг/л
Хаягдал ус 2024.08.17	<0.03	0.3	<0.1	0.2	0.146	<0.01	<0.0001	<0.001
MNS 4943:2015	200	500	50	20	50	1.5	0.001	0.1

Элемент	Co	Mn	Hg	Sr	Fe	Cr	Al
Нэгж	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л
Хаягдал ус 2024.08.17	0.0006	0.033	<0.0005	0.119	<0.005	<0.001	<0.001
MNS 4943:2015	0.02	0.5	0.001	2	1	0.3	0.5

Хаягдал усны шинжилгээгээр харьцуулах боломжтой 23 үзүүлэлтээс 23 үзүүлэлтийн агуулга нь MNS 4943:2015 стандарт нормыг биелүүлж байна.

Хөрс, газрын гадаргад үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Орчны хөрсний шинжилгээнд зориулан лабораторийн хашаанаас хөрсний дээж авч “SGS IMME Mongolia” ХХК-аар хүнд металл тодорхойлох химийн шинжилгээ хийлгэн MNS 5850 : 2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулсан. Хүснэгт 2-т шинжилгээний үр дүнг MNS 5850:2008 стандарттай харьцуулав.



Зураг 3. Хөрсний дээж авсан талбай

Хүснэгт 2. Хөрсөн дэх хүнд металлын агуулагыг MNS 5850:2019 стандарттай харьцуулсан үр дүн

Элемент	As	Co	Cu	Ni	Pb	Zn
Нэгж	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Хөрс 2024.08.18	5	6	17.5	10	23	54
MNS 5850:2019 Зөвшөөрөгдөх агууламж	5	50	100	150	100	300


Элемент	Cd	Cr	Sr	V	Mo	Sn
Нэгж	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Хөрс 2024.08.18	<1	22	206	37	<1	<10
MNS 5850:2019 Зөвшөөрөгдөх агууламж	3	150	800	150	5	50

Гадаад орчны хөрс (Хөрс 2024.08.18) -ний шинжилгээний үр дүнг MNS 5850:2019 стандартын зөвшөөрөгдөх агууламжийн утгатай харьцуулахад хөрсөнд агуулагдах хүнд

металлын агуулга зөвшөөрөгдөх хэмжээнээс бага буюу стандартыг биелүүлж байна. Ус, хөрсний шинжилгээний үр дүнг Хавсралт 1 -д хавсаргав.

Амьтны аймаг ба ургамлан нөмрөгийг хамгаалах арга хэмжээ

Манай лаборатори нь хотын төвд байрладаг учраас машин механизмын хөдөлгөөн, дуу чимээний нөлөөлөл ихтэйгээс энэ бүсэд ан амьтан амьдрах нөхцөл байдаггүй. Иймээс байгалийн амьтны аймагт төдийлөн сөрөг нөлөөлөл үзүүлэх нь бага болно.


№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хийгдсэн ажил
1	Ногоон байгууламж байгуулсан талбайнуудад ургамлан нөмрөг ургах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор шимт бодисын агууламжийг нэмэгдүүлэх, бордох	<p>2024 оны 5 сард Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороонд байрлах Сэлбэ голын эргээр 10 ширхэг бургас мод суулган шимт бодисын агуулгыг нэмэгдүүлэн бордсон. 7-8 сард болсон үерийн улмаас 6 мод нь үндсээрээ байхгүй болсон. 4 мод нь ургаж байна.</p>  <p>Зураг 2. Мод ургаж буй байдал</p>
2	Лабораторийн ариун цэврийн асуудлыг сайтар сахин ажиллах, шавьж, мэрэгч амьтдаар дамжин халдварт өвчин тархах магадлалыг бууруулах арга хэмжээ авах	Шавьж мэрэгч амьтадыг устгах зорилгоор шавьж устгал ариутгалын компанитай гэрээ байгуулан 6 сар тутамд нэг удаа устгал ариутгал хийлгэж байна. Мөн өдөр болгон цэвэрлэгээ ариутгал хийж ажиллаж байна.



Зураг 3. Устгал ариутгал

3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Лабораторийн орчимд эсвэл дүүрэг, хорооны захиргаанаас зааж өгсөн талбайд ургамлан бүрхэвчийг нөхөн сэргээх, тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлын хүрээнд Өөрийн байгууллагын дэргэдэх хашаанд жимсний мод болон гацуур суулгаж шимт бодисын агуулгыг нэмэгдүүлэн бордож ургуулж байна.



Зураг 8. Байгууллагын хашаанд ургаж буй жимсний мод болон гацуурууд
Мөн 2024 оны хавар сэлбэ голын эргээр 10 ш бургас суулгаж тарьсан.


4. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус лаборатори нь үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм боловсруулан ажиллаж, ашиглалтын талаарх мэдээллийг тогтмол гаргаж, холбогдох газраар хянуулж, ашиглах, эрсдлийн үнэлгээ гаргуулах, ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулах, аврах гарцын схем гаргах, сургалт явуулах, химийн бодисын агуулахыг засаж тохижуулах, химийн бодисуудыг ангилж хадгалах, материалын нэр, аюулын шинж чанар, анхааруулах тэмдгийг байрлуулах, засвар хийх, хана, цонхны амалгаануудыг засах, химийн материалтай харьцах сургалтуудыг зохион байгуулах, гал унтраах хэрэгслийг шалгах, хангах ажлуудыг хийж Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газрын байцаагчаар дүгнэлт гаргуулсан. Мөн Нийслэлийн Онцгой байдлын газраар ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт, Химийн ослоос урьдчилан сэргийлэх ослын үед ажиллах төлөвлөгөө батлуулан ажиллаж байна.

Ашиглагдаж байгаа химийн бодисуудыг тухай бүр нь химийн бодис зарах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжүүдээс/ Грийн химистри ХХК, Цэцүүх ХХК /бага хэмжээгээр нь хяналт, туршилт хийгдсэн баталгаа бүхий гэрчилгээтэй, мөн хор аюулын лавлахтай, бодис тус бүрийг тохирсон зориулалтын сав, хайрцагт савлаж битүүмжилсэн, хаяг шошготойгоор нь өөрсдийн хэрэгцээнд тохирсон хэмжээгээр авч агуулахад хадгалан ашиглаж байна.

Мөн технологийн горимыг чанд сахихгүй байх, ажиллагсдын хайнга ажиллагаа зэргээс үүдэн осол гарвал химийн бодисын хор аюулаас үүдэн бий болох эрсдэл, үр дагавар нь ноцтой тул урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах зорилгоор ХАБ-ын зааварчилгааг ажлын байранд өдөр бүр өгдөг.

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хийгдсэн ажил
Химийн бодисын сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдах, орчинд тархах	Нөөцөд тодорхой хэмжээний сав баглаа боодол цэвэрлэж, байлгах	Тодорхой хэмжээний сав баглаа боодол нөөцөнд худалдаж авсан.
	Шаардлагатай үед алдагдсан химийн бодисыг цэвэрлэх, саармагжуулах арга хэмжээ авах, багаж хэрэгсэлтэй болох	Алдагдсан химийн бодисыг цэвэрлэх, саармагжуулах анхан шатны багаж хэрэгслээр хангагдсан. Үүнд: -Шингэн бодисын зориулалтын шингээгч материал -Хуурай бодисын тосгуур, шүүр, зориулалтын хаягдлын уут -Комбинзон -Хүчилтөрөгчтэй маск

		
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх гарын авлагатай болох	Өрөө тасалгааны температур, чийгшилийг ажлын өдрүүдэд тогтмол шалгаж, бүртгэл хөтөлдөг.
	Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай болох	Химийн лабораторид ажиллаж байгаа ажилчдад өдөр бүр ХАБ-ын заавар өгч, гарын үсэг зуруулж байна. Аюулгүй ажиллагааны зааварчилгааны самбарыг тогтмол ажиллуулж байна.
	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл, холбооны хэрэгсэлтэй болох	Болзошгүй аюул ослыг урьдчилан мэдэгдэхэд шаардлагатай утаа мэдрэгч, галын дохио суурьлуулж өгсөн. Осол гарсан үед ашиглах зорилгоор гал унтраах багаж, галын хор, усны гидрант, албан байгууллагын утасны дугааруудыг лабораторийн өрөө бүрд байрлуулсан.
Химийн бодис алдагдах, асгарах зэргээр ажилчдын эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй	Ажилчдад хүчил шүлтэнд тэсвэртэй зориулалтын хөдөлмөр хамгааллын хувцас өмсгөх, зориулалтын угаалгын өрөөнд угааж, цэвэрлэх	Ажилчид хүчил шүлтэнд тэсвэртэй зориулалтын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангагдсан.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хийгдсэн ажил
1	Лабораторийн химийн бодисын агуулах	<ul style="list-style-type: none"> – Химийн хорт болон аюултай бодисын агааржуулалтыг сайжруулах – Химийн бодистой харьцах асгарах үед авах арга хэмжээ аюулын тухай ажилтнуудад сургалт хийх – Нийт ажилтнуудад асгаралтын үед авах арга хэмжээний тухай сургалт зохион байгуулах – Асгаралтын үед ашиглах шаардлагатай нөөцөөр хангах зэрэг ажлуудыг хийсэн.

5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Лабораторийн үйл ажиллагааны дүнд үүсч буй хог хаягдлын байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах зорилготойгоор ажиллаж байна. Манай лаборатори нь аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг ялган ангилж савлаж хаях, үлдсэн хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор устгах зарчмыг баримтлан хог хаягдлыг зүй зохистой удирдан зохицуулахыг зорин ажиллаж байна. Энэ зорилгын хүрээнд:

- Ангилал тус бүр дэх хогийг цуглуулах, хадгалах, тээвэрлэх ба зайлуулах явцад үүсэх шинж чанарыг тодорхойлж хортой хог хаягдлыг зориулалтын саванд агааржуулалт сайтай өрөөнд хадгалж байна. Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, нийслэлийн тохижилт үйлчилгээний газартай гэрээ байгуулан тээвэрлүүлдэг. Захиалагчаас ирсэн хүдэр баяжмал, чулуулгын дээжийг шинжилсэний дараа захиалагчидад буцаан өгдөг.
- Дахин ашиглагдах болон дахин боловсруулагдах хог хаягдлын үр дүнтэй зохицуулалт хийхдээ зориулалтын сав байрлуулж цуглуулдаг.

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ
Ахуйн хог хаягдлыг ил задгай хаяснаас таагүй нөхцөл байдал үүсэх	Хог хаягдлыг ангилан зориулалтын тусгай саванд цуглуулдаг.
	Ариутгал цэвэрлэгээний ажлыг тогтмол хийдэг.
	Ахуйн аюулгүй хог хаягдлыг тогтмол хугацаанд тээвэрлэлтэнд өгч байна.
Химийн бодисын хаягдал үүсэх, байгаль орчинд нөлөөлөх	Химийн бодисын сав баглаа боодол болон бусад хатуу хог хаягдалыг “Түмэн эгшиг” ХХК болон “Цэцүүх” ХХК-д гэрээний дагуу шилжүүлж байна. Аюултай шингэн хаягдлыг Элемент ХХК-тай хийсэн гэрээний дагуу шилжүүлж байна.

6. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Манай лаборатори нь 2018 оны 7 дугаар сараас үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд энэ хугацаанд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу удирдлагын зүгээс хяналт тавьж ажиллаж байна. Мөн үйл ажиллагаа болон байгууллагын дотоод журмандаа Байгаль орчны тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэмд нийцүүлэн ажиллахыг зорьж байна. Нийслэлийн ОБЕГ-аар лаборатори дээрээ хяналт хийлгэж ажилчдынхаа дунд галын аюулгүй байдал, химийн бодистой аюулгүй ажиллах, хөдөлмөр хамгааллын сургалтуудыг зохион байгуулах, осол эрсдлээс хамгаалах зэрэг ажлыг зохион байгуулсан. Мөн лабораторийн гадгаш гарч байгаа агааржуулалтын хоолойд нүүрсэн филтерүүд суурилуулсан болно. 2024 оны 9 сарын 20-оос 10 сарын 17 хооронд MNS ISO /IEC 17020 стандартын дагуу WHA ХХК-аар Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ, хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ хийлгэсэн. Үнэлгээний тайлангийн дагуу зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

MNS ISO 45001: 2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-шаардлага хэрэглэх заавар, MNS-5029:2011 Химийн хорт бодисын шошго анхааруулах тэмдэглэгээ, MNS-6458-2014 Хөдөлмөрийн аюулгүй ажилгаа эрүүл ахуй химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүнийг агуулах зэрэг стандартуудыг мөрдөн ажиллаж байна.

Ажилчдад ажлын байрны онцлог тус бүрт нийцсэн ажлын хувцас хэрэгслээр хангаж, химийн бодистой харьцан ажилладаг ажилтанд хор саармагжуулах бүтээгдэхүүнийг ажлын байранд өдөр бүр тогтмол олгож байна.

Мөн ажилчдын ажлын хувцас нь ажлын байрны онцлог тус бүрт нийцсэн байхаас гадна улирлын чанартай хувцас хэрэгсэл ажлын байранд яаралтай үед хэрэглэх түргэн тусламжийн багаж хэрэгсэл, эм тариагаар хангагдсан.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хийгдсэн ажлууд	Тоо хэмжээ, ш	Нэгжийн үнэ, ₮	Нийт үнэ, ₮
0	1	2	3	4	5	6
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	750000	Агаар шүүгч фильтр	8	40000	320000
			Лед гэрэл	8	30000	240000
			Ариутгал халдваргүйжүүлэлт	4	50000	200000
		-	Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ	1	4000000	4000000
		-	Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ	1	4000000	4000000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	150000	Бургас	10	15000	150000
3	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	600000	Ахуйн хог хаягдал	12	50000	600000
			Аюултай хог хаягдал	4	300000	1200000
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	570000	Агаар -1	-	-	0
			Хөрс - 2	2	40000	80000
			Ус - 2	2	40000	80000
	Нийт	2,270,000				10870000

ДҮГНЭЛТ

Манай лаборатори нь 2017 оны 7 сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд үндсэн үйл ажиллагааныхаа зэрэгцээ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.

2018 оны 3 дугаар сард Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийгдсэн. 2022 оны 7 сарын 6-нд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ дахин хийгдсэн.

Баягаль орчны хяналт шинжилгээнд лабораторийн ойр орчмын хөрс болон хаягдал усны шинжилгээг “SGS-IMME Mongolia” ХХК-аар хийлгүүлж үр дүнг MNS 4943:2011, MNS 5850:2008 стандарттай харьцуулсан. Шинжилгээний үр дүн нь эдгээр стандартуудын зөвшөөрөгдөх хязгаарт байна.

Энэ хугацаанд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг аль болох бууруулах чиглэлээр хог хаягдлыг ахуйн болон аюултай гэж ангилан ялгаж, ахуйн хог хаягдлыг нийслэлийн тохижилт үйлчилгээний газраар тээвэрлүүлэн ачуулж, химийн хортой хатуу хог хаягдлыг зориулалтын уутанд битүүмжлэн хадгалж, шингэн хортой хаягдлыг саармагжуулан битүүмжлэл сайтай зориулалтын саванд хадгалж аюултай хог хаягдал устгах зөвшөөрөлтэй гэрээт компаниудад шилжүүлж байна.

Үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа химийн бодис урвалжийг Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон MNS 6458:2014 химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах стандартын дагуу тохижуулсан өрөөнд хадгалж байна.

Ажилчдынхаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор ажлын хувцас хэрэглэлийг бүрэн өмсөх, ХАБЭА-н зааварчилгаа өгөх, ХАБЭА-н сургалтанд хамрагдах, хор саармагжуулах бүтээгдэхүүн өдөр бүр хэрэглэх, жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулах гэх мэт ажлуудыг хэрэгжүүлж байна.

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД:

- Хавсралт -1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэмжилт, дээжлэлт хийж буй агшныг баталгаажуулсан, төсөл хэрэгжиж буй орчны фонтой хамт авсан гэрэл зураг /цэг бүр дээр 2-оос доошгүй/
- Хавсралт -2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийг баталгаажуулсан гэрэл зураг /арга хэмжээ бүрт 2-оос доошгүй орчны фонтой хамт авсан гэрэл зураг хавсаргах/
- Хавсралт -3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн гүйцэтгэлийг харуулсан гэрэл зураг /нэгж талбай бүр дээр хийхээс өмнө, хийж байх үеийн, хийсний дараах байдлыг харуулсан гэрэл зургууд хавсаргах/
- Хавсралт -4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийсэн хээрийн хэмжилт, авсан дээжнүүдийн лабораторийн шинжилгээний үр дүн эх хувиар
- Хавсралт -5 Орон нутагтай байгуулсан хог хаягдлын гэрээ

Тайлбар: Бүрэлдэхүүн хэсэг тус бүрт биелэлтээс нь хамааран авсан байвал зохих оноог тогтоосон ба ажлын хэсгийн гишүүн тус бүрийн өгсөн онооны энгийн арифметик дунжийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрт тооцож гаргана. Гишүүдийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт өгсөн онооны энгийн арифметик дунжийн нийлбэр нь нийт оноо болно. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийн биелэлтийн нийт оноо нь 90-ээс доош байвал төлөвлөгөөний биелэлтийг хангалтгүй гэж үзнэ. Тухайн жилд түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй бол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт рүү шилжүүлж тооцно.

Ажлын хэсгийн дарга: _____
/ _____ /

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: _____
/ _____ /

Гишүүд:

Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч _____ / _____ /

Байгаль орчны асуудал хариуцсан газрын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн _____ / _____ /

Сав газрын захиргааны ус ашиглагч хариуцсан мэргэжилтэн _____
/ _____ /

Сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч _____ / _____ /

Тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагч _____ / _____ /

Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл _____ / _____ /

Хүлээн зөвшөөрсөн:

Геоаналитик ХХК-ийн захирал _____ /Э. Мөнхбаатар/

Хавсралт -1.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэмжилт, дээжлэлт хийж буй агшныг баталгаажуулсан, төсөл хэрэгжиж буй орчны фонтой хамт авсан гэрэл зураг




Зураг 1. Технологи туршилтанд ашиглагддаг шлихийн дээж угаалтаас гарах хаягдал уснаас шинжилгээний дээж авч буй байдал



Зураг 2. Лабораторийн гадаад орчноос хөрсний дээж авч буй байдал

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийг баталгаажуулсан гэрэл зураг /арга хэмжээ бүрт 2-оос доошгүй орчны фонтой хамт авсан гэрэл зураг хавсаргах/



Зураг 1. Лабораторийн агааржуулалтын системийн төгсгөлд том ширхэгтэй тоосонцор болон хүнд металлыг шүүх зориулалттай нүүрсэн филтер суурилуулсан байдал

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн гүйцэтгэлийг харуулсан гэрэл зураг /нэгж талбай бүр дээр хийхээс өмнө, хийж байх үеийн, хийсний дараах байдлыг харуулсан гэрэл зургууд хавсаргах/



Зураг 1. Лабораторийн хашаан дотор ургаж байгаа жимсний моднууд



Зураг 2. Лабораторийн хашаан дотор ургаж байгаа гацуурнууд



Зураг 3. Сэлбэ голын эрэгээр ургаж буй бургаснууд

